



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/134

Арвайхээр

**Зарим үйлчилгээний газруудын үйл ажиллагааг
хязгаарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, аймгийн Шуурхай штабын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны томоохон төвүүд (Номин, Арцат трейд, Молор, Арвин), барилгын материал, бичиг хэрэг, гэр ахуйн барааны дэлгүүр, нийтийн хоолны газрууд, дугуй засварын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 18.00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06.00 цаг хүртэл түр зогсоосугай.

2.Улсын чанартай А0301 автозам дагуу байрлах худалдаа үйлчилгээ, хүнсний дэлгүүрүүд болон хоол үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс түр зогсоохыг Арвайхээр, Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100295